

## Орон нутгийн төсвийн мониторинг

Баянхонгор аймгийн ХЭҮТСалбар нь 2006 онд Дэлхийн банкны санхүүжилтээр Баянхонгор, Богд, Баянговь, Баянлиг сумдыг хамруулан Орон нутгийн засаглалын түвшинд хүний эрх, жендер, гэр бүл, хүүхэд, эмэгтэйчүүдийн болон гэр бүл дэх хүчирхийллийн эсрэг асуудлаар баримталж буй бодлого, хөтөлбөр, шийдвэрүүд, тэдгээрийн хэрэгжилт; бодлогын шийдвэр гаргах түвшинд ТББ-ууд, иргэдийн оролцоонд дүн шинжилгээ хийх замаар тэдгээрийг уялдуулах арга замыг тодорхойлох судалгаа хийсэн юм. Судалгаанаас харахад:

- ✚ Орон нутагт баримталж буй бодлого, хэрэгжиж буй хөтөлбөр төслүүдэд хүний эрх, жендер, гэр бүлийн хүчирхийллийн асуудлаар бүрхэг, ерөнхий заалт оруулсан, хэрэгжүүлэгч субъектээ зөв тодорхойлоогүй, тусгасан асуудлыг хэн, хэзээ, хэрхэн хэрэгжүүлэх арга зам нь тодорхойгүй;
- ✚ Үндэсний хэмжээнд батлагдаж буй бодлого, хөтөлбөр бүрийн санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх талаар тухайн жилийн улсын төвлөрсөн болон орон нутгийн төсөвт тусгахыг Сангийн яам, холбогдох яамд, аймаг, нийслэл, сум дүүргийн Засаг даргад хариуцуулахаар заасан байдаг боловч орон нутгийн төсөв нь цаанаасаа зардлын зүйл ангиар хуваарилагдсан байдаг учир төрөөс баримталж буй бодлого, хөтөлбөр, төслүүдийг санхүүжүүлэх боломжгүйгээс тунхаглалын шинжтэй байдаг, тусгагдвал зохих олон асуудал хөрөнгө санхүүгийн эх үүсвэргүйгээс орхигдох буюу хагас дутуу тусгагдахад хүрдэг;
- ✚ Орон нутгийн засаг захиргаа төрөөс батлан гаргасан хөтөлбөрүүдийг орон нутагт хэрэгжүүлэхээр дэд хөтөлбөр гаргадаг ч тэр нь зөвхөн ам хаасан шинжтэй, хэн нэгэн албан тушаалтны ширээний нүдэнд ороод мартагддагаас шахалт үзүүлэх, хяналт тавих, хариуцлага тооцох механизм байдаггүй;
- ✚ Орон нутагт баримталж буй бодлого, хэрэгжиж буй хөтөлбөр төслүүдийн талаар иргэд, олон нийтэд мэдээлэх, тэдгээрийн хэрэгжилт, үнэлгээнд иргэний нийгмийн байгууллагуудын оролцоо хангалтгүй зэрэг нийтлэг дутагдлууд байгаа юм.

### Төслийн зорилго

Төрөөс батлан гаргасан хөтөлбөрүүдийг бодитой, үр дүнтэй хэрэгжүүлэх арга замыг тодорхойлох, бодлого боловсруулах, хэрэгжүүлэх үйл явцад иргэний нийгмийн оролцоог хангаж, чадавхжуулах

### Төслийн зорилтууд :

- ✚ Орон нутгийн түвшинд баримталж буй бүх бодлого, хөтөлбөр, төслүүдийг аймгийн төсвөөс санхүүжүүлэх боломж болон тэдгээрийг шалгаруулж, санхүүжүүлэх суурь хэмжигдхүүн, үзүүлэлтүүд
- ✚ Орон нутгийн төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлийн үйл явц, түүнийг зарцуулах, хяналт тавих түвшинд иргэний нийгмийн оролцооны өнөөгийн байдлыг тодруулах
- ✚ Орон нутгийн хөгжлийн бодлого боловсруулагчид, хэрэгжүүлэгчдэд зөвхөн төрийн албан хаагчдыг хамруулан ойлгож байгаа өнөөгийн хэвшмэл ойлголтоос салах, орон нутгийн иргэний нийгмийн байгууллагууд бас энд чухал үүрэгтэйг анхааран, тэдний мэдлэг, чадварыг дээшлүүлэх, мэдээллээр хангах, хамтран ажиллах арга зүйг тодорхойлон чадавхийг бэхжүүлснээр

цаашид бодлого боловсруулах, шийдвэр гаргах түвшинд нөлөөлөх зорилго бүхий чадавхижсан хамтын ажиллагааны сүлжээ бий болгох.

## **2. МОНИТОРИНГИЙН АРГАЧЛАЛ**

### **1. Баг бүрдүүлж, мониторингд бэлтгэх**

1.1. Иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл 5 хүн болон зөвлөхийн бүрэлдхүүнтэй баг бүрдүүлэн мониторингийн удирдамжийн дагуу ажлын нарийвчилсан төлөвлөгөө, судалгааны удирдамж, асуулгыг боловсруулсан.

1.2. 2006 оны 12-р сард хуралдсан АИТХ-ын ээлжит хуралдаанд ажиглагчаар оролцсон.

### **2. Мэдээлэл буюу өгөгдөл цуглуулах**

Хяналт үнэлгээг хийхдээ социологийн судалгааны тоон болон чанарын аргуудыг хамтад нь уялдуулан хэрэглэсэн. Тоон аргад статистик болон асуулгын шинжилгээг, чанарын судалгаанд баримт бичиг судлах арга, фокус бүлгийн ярилцлагын арга, сурвалжлагын аргуудыг хэрэглэн бодитой оршин буй асуудлыг үр дүнтэй шийдвэрлэхэд шаардлагатай мэдээллийг цуглуулахдаа

1. Баримт бичиг судлах буюу орон нутгийн 2000 - 2006 оны төсөв, аймгийн ЗД-ын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, аймгийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэл, аймгийн засаг даргын захирамж, орон нутгаас санхүүжүүлсэн хөтөлбөр, төслүүдэд дүн шинжилгээ хийх

2. Асуулгын аргаар сонгож авсан 5 сумын 50 иргэнээс орон нутгийн төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлийн үйл явц, түүнийг зарцуулах, хяналт тавих түвшинд ТББ-ууд, иргэдийн оролцооны өнөөгийн нөхцөл байдлыг үнэлж, тэдгээрийг сайжруулах боломжийн талаарх оролцогчдын санаа бодлыг тодруулах, шаардлагатай байгаа үйл ажиллагааг тодорхойлох судалгаа авах

3. Зорилтот бүлгийн ярилцлага зохион байгуулж, 5 суманд тус бүр 8 - 10 хүнийг хамруулах

4. Сурвалжлагын арга буюу чухал мэдээлэгч 3 хүнтэй биечлэн ярилцаж, хөтөлбөр, төслүүдийг шалгаруулж, санхүүжүүлэх суурь хэмжигдхүүн, үзүүлэлтүүд, тэдгээрийг санхүүжүүлэх тогтолцоо нь гүйцэтгэл, үр дүнгийн үзүүлэлттэй ямар нэгэн уялдаа холбоотой эсэх талаар шаардлагатай нэмэлт мэдээллийг бүрдүүлэх зэргээр ажиллав.

### **3. Цуглуулсан мэдээллээ боловсруулан, мониторингийн тайлан гаргах**

3.1. Мэдээллүүдээ нэгтгэсэнээр үнэлгээнээс ямар асуудлуудыг олж мэдсэнээ тоймлон гаргаж, нийтлэг зүйлүүд юу байгааг тодорхойлж, тулгамдсан асуудал, түүнийг шийдэхийн тулд ямар арга хэмжээ авах талаарх зөвлөмж, дүгнэлтийг боловсруулна.

### Асуудлын мод

Хөтөлбөр, төслүүдэд тусгасан асуудал шийдэгдэлгүй үлддэг.	Хөтөлбөр, төслүүдийн хэрэгжилтэнд хариуцлага тооцдоггүй.	Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлд иргэний нийгмийн оролцоо байхгүй.	
Хууль хэрэгждэггүй.	Иргэдийн мэдлэг, мэдээлэл дутмаг.	Хөтөлбөр, төслүүдийг санхүүжүүлэхдээ тэгш бус ханддаг.	
Хөтөлбөр, төслүүд хэрэгждэггүй, хэн нэгэн албан тушаалтны ширээний нүдэнд дарагдаж үлддэг.			
Орон нутгийн төсөв хүрэлцээгүй.	Хөтөлбөр, төслүүдийг санхүүжүүлэх шалгуур үзүүлэлт, аргачлал байхгүй.	ИТХ-ын төлөөлөгчид төсөв болон хөтөлбөр, төслүүдийн талаар мэдлэггүй.	Орон нутгийн төсвийн төлөвлөлт, зарцуулалт нээлттэй, ил тод бус.

### Зорилго, зорилтын мод

Хөтөлбөр, төслүүдэд тусгасан асуудал шийдэгддэг болно.	Хөтөлбөр, төслүүдийн хэрэгжилтэнд хариуцлага тооцдог болно.	Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлд иргэний нийгэм оролцдог, хяналт тавьдаг болно.	
Хуулийн хэрэгжилт сайжирна.	Иргэдийн мэдлэг, мэдээлэл сайжирна.	Хөтөлбөр, төслүүдийг санхүүжүүлэхдээ шударга, тэгш ханддаг болно.	
Хөтөлбөр, төслүүд хэрэгждэг болно.			
Хязгаарлагдмал төсвийн хүрээнд оновчтой үйл ажиллагаа явуулдаг болно.	Хөтөлбөр, төслүүдийг санхүүжүүлэх шалгуур үзүүлэлт, аргачлал буй болно.	ИТХ-ын төлөөлөгчид төсөв болон хөтөлбөр, төслүүдийн талаар мэдлэгтэй болно.	Орон нутгийн төсвийн төлөвлөлт, зарцуулалт нээлттэй, ил тод болно.